



2nd Story

Амлагдсан Есүс ирэв

Jesus' Birth

Амлагдсан Есүс ирэв

– 2nd Story –



Хүүрнэгч Бүх хүмүүс өөрийн төрсөн нутагруугаа буцаж иргэний бүртгэлээ шинэчлэх тушаал буув. Ромын Эзэн хаан өөрийн захирч буй бүх хүмүүсийн нэрсийг мэдэхийг хүсэж байв. Иймээс Иосеф болон Мариа нар Галилыг орхин Бетелхем руу явах аялалдаа гарав. Мариа төрөх дөхсөн учир хурдхан очоод буцахыг хүсэж байв.

Иосеф Илжиг минь дээ~~ алив нааш ир л дээ~~~ Мариа маань энд төрж болохгүй биз дээ~~

Хүүрнэгч Иосеф болон Мариа нар толгой хорогдох газар хайж байлаа. Гэтэл гэнэт Мариагийн гэдэс өвдөж эхлэв. Удахгүй бяцхан Есүс төрөх гэж байх шиг байна.

Мариа яанаа аааааааа Иосеф!!!!!! Яг одоо.. одоо шүү ~!!
Би~төрлөө~төрлөө...

Иосеф ӨӨ маая гаад! Өө маая!! Ер нь одоо хаачих вэ? Яадаг билээ...чи минь жаахан тэвчээрэй

Хүүрнэгч Иосеф шөнийг л өнгөрөөчих өрөө хайж ихэд л хичээж байв. Гэвч хаашаа ч очсон битүү хүнтэй байв. Ямар ч хүн өрөөгөө өгөх боломжгүй байлаа.

Иосеф Уучлаарай, танайд өрөө байгаа юу?

Дэн буудлын эзэн1 Байхгүй ээ ~~!! Ороод хар л даа.

Иосеф Сайн байна уу~~ танайд өрөө байхгүй биз?

Дэн буудлын эзэн2 манайд өрөө алгадаа, нилээд оройтчихлоодоо.

Иосеф Үгүй ээ~~ үнэхээр уучлаарай. Үнэхээр ганц ч өрөө байхгүй юм уу? Манай эхнэр удахгүй төрөх гээд байгаа юм л даа.

Дэн буудлын эзэн3 Байхгүй ээ байхгүй.

Иосеф Жижигхэн өрөө ч болтугай байхгүй юм уу?

Дэн буудлын эзэн3 Байхгүй ээ


Иосеф КЗүгээр коридорт ч байтугай байж болохгүй юм уу?

Дэн буудлын эзэн3 Өө чи чинь яасан төвөгтэй хүн бэ?

Хүүрнэгч Иосеф хотын бүх дүүрэг хороогоор явсан ч Бетелхемд нэг ч өрөө байхгүй байлаа. Эцэст нь Иосеф болон Мариа хоёр морины хашааны хажуугаар явахаар болов.

Мариа Иосеф, Иосеф! Хоёулаа энд буудаллалаа аа. Яг одоо!





Иосеф Энд үү? Энэ чинь адуу мал хашдаг газар байна шүү дээ?

Мариа Тиймээ энд, энд.

Иосеф за тэгье тэгье.

Хүүрнэгч Мариа, амьтан малаар дүүрэн хашаанд Есүсийг төрүүлэв.
Илжиг, хонь бас тэмээ байгаа газар шүү.

Мариа Эгдүүтэй бидний бяцхан хүү Есүс.

Иосеф Үнэхээр эгдүүтэй юм аа, яг л намайг дуурайчихсан байна
шүү хэхэ

Хүүрнэгч Гэсэн ч Мариа Иосеф хоёр малын хашаа ч болтугай
байгаад нь үнэхээр ихэд талархаж байв. Тэд бяцхан
Есүсийг өгсөн Эзэн Бурхандаа талархаж байлаа. Бурхан
тэднийг болоод Хүүг ерөөв. Бурханы Хүү~
Иосеф болон Мариагийн хорогдож байсан малын
хашааны ойролцоо хоньчид амьдардаж байв. Тэднийг
хариулж байхад нь тэнгэр элч нар гарч ирэв.

Тэнгэр вааав~~

Тэнгэр элч нар Бурханд алдар нь байг~!!

Хоньчид ваававааааүүүүүүүүүүүү~!!

Тэнгэр элч ваав үү ваав үү~~!! Биднээс болж бүү айхтун~~!! Бид бүх
хүмүүст баярт мэдээг хүргэхээр ирсэн. Өнөөдөр
Бетелхемд Аврагч мэндэллээ. Jesus Christ~~~Христ Есүс
бол бүх дэлхийн Аврагч шүү. Та бүхэн эхийнхээ тэвэрт
байгаа өлгийтэй Хүүг малын хашаанд очвол харах болно.

Хоньчид Айн? Юу гэнээ?

Хүүрнэгч Хоньчид тэнгэр элч нарын үгэнд гайхширав. Тэд малын
хашаа руу яаравчилж үзэхээр очив. Тэд малын хашаанд
очиж Иосеф болон Мариа нарт тэнгэр элч өөрсдөд нь юу
гэж хэлснийг хэлэв. Үүнийг сонссон Мариа болон Иосеф
нар ихэд гайхав.

Тэнгэр элч тэдэнд – Бүү айгтун, харагтун, би бүх ард
түмнийг үлэмж баярлуулах сайхан мэдээг та нарт
авчирлаа. Өнөөдөр, Давидын хотод Аврагч Эзэн Христ
та нарын төлөө мэндэллээ. Лук2:10-11